

**7-Р АНГИЙН МОНГОЛ ХЭЛ ХИЧЭЭЛИЙН АНГИ
ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ**

2024.05.25

ХУГАЦАА 60 мин

“С” вариант

1.Эхээ анхааралтай сайтар уншиж ойлгож дараах даалгаврыг гүйцэтгэх.

2. Тусдаа цаас гарган даалгаврыг гүйцэтгэх .

АЯН ЗАМЫН ТЭМДЭГЛЭЛ

1967.07.27

Нартай тунгалаг сэрүүн сайхан өглөө бид нисэх онгоцонд суугаад Бээжин орохоор явлаа.

Улаанбаатарын өмнөх өндөр сайхан уул маань сүндэрлэсээр хоцорлоо. Өргөн шар тал маань мэлтийсээр үлдлээ. Төмөр замаар яваа хурдан галт тэрэгнүүд, нисэж яваа бидэнд их л удаанаар мөлхөж яваа юм шиг харагдаж байна. эсгий гэр, бэлчиж яваа мал үргэлжлэн харагдаж байна.

Говийн бүдүүн тэмээнүүд шагайн чинээ жижигхэн улаан юм болоод харагдаж байна.

Өвөр Монголын элсэрхэг тал нутаг, олон жижигхэн нуурууд аягатай сүү шиг мэлтэлзээд өнгөрч байна. тэгээд урьд тэмээн тэргээр нэг сар явж хүрдэг, галт тэргээр хэдэн хоног явж хүрдэг Бээжин хотод бид гурван цаг хагас нисээд хүрчихлээ.

Биднийг “Бээжин Фандян” гэдэг том буудалд буулгав. Өмсөж очсон дээл хувцас маань нэвсийж хөвсийгөөд их л зузаан болчихсон юм шиг санагдлаа. Цаг улирал нь халуун болохоор ноосон даавуу хувцсыг харахад ч халууцмаар байна. Ц. Дамдинсүрэн

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: Эхийг уншаад даалгаврыг гүйцэтгээрэй

1. Эхийн гол санааг илэрхийлсэн хэсгийг олж тэмдэглээрэй. . \2 оноо\

А. Эх орон минь хамгаас эрхэм

Б. Эх нутгаас гараад эх нутгаа санадаг.

В. Аян замын тэмдэглэл

Г. Эх нутгаа санах сайхан.

2. Эхэд байгаа тэмдэг нэрийг ялган бичээрэй

\2 оноо\

Өнгө зүс , хэлбэр хэмжээ заасан тэмдэг нэр	Шинж чанар заасан тэмдэг нэр

3.Дараах үгс юуг юутай зүйрлэснийг олж бичээрэй

\2оноо\

Мөлхөж яваа юм шиг

Аягатай сүү шиг мэлтэлзээд

4. Дараах шүлгийн цэгийн оронд тохирох дуурайх үгс бичээрэй. \2 оноо\

Борхон саарал туулай үсэрч
Боролж шугуйн дундуур дэвхрэхэд
Босоо хоёр чих нь хайчилж
Богино хархан сүүл нь хөдөлнө.

5. Хатуу зөөлний тэмдгийн үүрэг: Дараах дүрэмд тохирох жишээ үгс бичих . \2 оноо\

- Зөөлний тэмдгээр төгссөн үйл үндсэнд шийдэн хүсэх я, ё нөхцөл залгавал зөөлний тэмдэг зөөлрүүлэх , тусгаарлах хоёр үүрэг гүйцэтгэнэ. Жишээ нь :
- Язгуур нэр үгийн бүтцэд зөөлрүүлэх, тусгаарлах хоёр үүрэгтэй зөөлний тэмдэг бичнэ.
Жишээ нь :

6. УРАН ЗОХИОЛ: Шүлгийн дараагийн мөрийг олж бичээд, хэний ямар зохиол болохыг бичээрэй.

.....шүлэг 5 оноо

1. Ооны халиун зоо шиг саруул талд
2. Онгин цагаан тамга шиг тэр барьсан юм.
3. Онон голын савд хур шиг адуунаас
4. Онгон загалыг мөнгөн сойсон юм.

А. хяруунд Б. халхын В. гэрээ Г. шаагих

7. МОНГОЛ БИЧИГ: Дараах өгүүлбэрийг хөрвүүлж бичээрэй. \5 оноо\

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠪᠢᠴᠢᠭᠢᠨ ᠲᠠᠷᠠᠭᠠᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠮᠥᠷᠢᠶᠢᠭᠡᠨ ᠣᠯᠵᠢ ᠪᠢᠴᠢᠭᠡᠳᠡ, ᠬᠡᠨᠢᠶᠢ ᠶ᠋ᠢᠮᠠᠷ ᠵᠣᠬᠢᠶ᠋ᠣᠯ ᠪᠣᠯᠣᠬᠢᠶᠢᠭᠡᠳᠡ ᠪᠢᠴᠢᠭᠡᠷᠡᠢ.

.....

.....

.....

.....

7-Р АНГИЙН МОНГОЛ ХЭЛ ХИЧЭЭЛИЙН АНГИ
ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

2024.05.25

ХУГАЦАА 60 мин

“Б” вариант

НУТГИЙН ЧУЛУУ

Хад шиг бат хүн байдаг. Хүн шиг бат хад байдаг. Манай нутаг хад чулуу ихтэй. “Хүн ардынхаа түүхийг хадгалсан тоолж баршгүй олон хуудастай чулуугаар бичсэн нэвтэрхий толь бичиг монгол нутагт буй.

Хавцгайтын амыг өгсөв. **Эгц эгц хад, өндөр өндөр цохио хоёр талд зарим газраа тольтон гялтайж, нэлэнхүйдээ тольтон хүрлийн сүүхийнэ. Хараа цуцам өндөр хадны орой, элгэн биед сангас цайран харагдах нь бүргэд ёл, тасын үүр аж.**

.. Замын хажуугийн чулуунд өнгө өнгийн хаг алаглан харагдана. Энэ жил хад их сайхан цэцэглэжээ. Энэ цэцэг зуны халуун, өвлийн хүйтэнд өнгө алддаггүй. Чулууны цэцэг гэж байхад чулууны өвчин гэж байдаг. Цэцэг нь чулуундаа, өвчин нь хүнд байдаг ажгуу.

1. Эхийн гол санааг илэрхийлсэн хэсгийг олоорой. \2оноо\
А. Чулуу бүхэн өөрийн түүхтэй Б. Чулуунаас түүхийг мэдэж болно.

В. Чулуунд цэцэг байдаг. Г. Чулуунд хаг байдаг.

2. Дээрх эхээс дүрслэх ур маягтай өгүүлбэрийг түүвэрлэн бичих. \2 оноо\

.....
.....

3. Дараах үгсийг тодруулж буй үгсийг эхээс олж бичээрэй. \2 оноо\

..... хад, цохио,хадны орой

Энэ цэцэг зуны, өвлийн хүйтэнд :

4. Тохирох утгад зөв харгалзуулах, ямар нийлмэл үгийн бүтэц вэ? 2 оноо

.....

1. Нөхцөлөөр а.ба, бөгөөд, буюу, харин, байтугай

2. Хэлэх аялгаар б.ж, ч, аад, н, саар

3. Холбоосоор в. хэлц, зүйр үг

5.Дараах өгүүлбэр дэх үйл үгийг бүтээврээр задлан, зөв бичих дүрмийг тайлбарлаарай.

\2 оноо\

“ ХЭВШЬЕ”

.....
.....
.....

6.. Уран зохиол :

Дараах сургаалын зохиолын дутуу үгийг нөхөж бичээрэй. \5 оноо\

Өдөр явсан явдлыг шөнө

Ичгүүр гэмт явдлыг ятгаж

Олны дотор үгээ

Ганцаар суухдаа сэтгэлээ

Ер авах гээхийн ялгалыг

7.МОНГОЛ БИЧИГ: Дараах өгүүлбэрийг уншаад хөрвүүлж бичээрэй.

~~1. МОНГОЛ БИЧИГ: Дараах өгүүлбэрийг уншаад хөрвүүлж бичээрэй.~~

.....
.....
.....
.....
.....
.....
.....